



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 11/193

Улаанбаатар хот

Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн
төлбөрийн хэлбэрээр орлуулан хаалгах,
иргэдийн нэрийг батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Цэргийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, 31 дүгээр зүйлийн 31.2, 31.6 дахь хэсэг, Улсын их хурлын 2009 оны 33 дугаар тогтоол, Засгийн газарын 2016 оны 215 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн харъяат хугацаат цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрч цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаалгах иргэдийн нэрийг хавсралтаар баталсугай.

2.Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдийн мөнгөн төлбөрийг хууль, журмын хүрээнд тогтоох, төлбөрийн гүйцэтгэлд хяналт тавьж, цэргийн үүргийн биелэлтийг хангуулж ажиллахыг Цэргийн штаб (хурандаа Ш.Бат-Өлзий)-т, мөнгөн төлбөрийг холбогдох дансанд төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Мягмарсүрэн)-т тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL\2024 он ажил\захирамж

1123200530